

ХААН БАНК ХК-ИЙН 2024 ОНЫ 1-Р ХАГАС ЖИЛИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Хагас жилийн үйл ажиллагааны тайлан /маягт 2/			
Тайлагнах хугацаа	2024 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс 2024 оны 6 дугаар сарын 30-ны өдөр		
Үнэт цаас гаргагчийн мэдээлэл	Нэр:	ХААН Банк ХК	
	УБГД:	000283102	
	РД:	2693321	
	Үнэт цаасны үсгэн тэмдэг:	MN0KHAN05637	
	Хаяг:	ХААН Банк Цамхаг, Чингисийн Өргөн Чөлөө-6, Стадион Оргил-1, Хан-Уул Дүүрэг 15-р хороо, Улаанбаатар 17010, Монгол Улс	
	Утас:	1800-1917, 7515-3333/3221/, 7507-1917	
	И-мэйл:	investor_relations@khanbank.com	
	Вэбсайт:	www.khanbank.com	
Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр	Монголын хөрөнгийн бирж ТӨХК		
Бизнесийн үйл ажиллагааны салбар	Банк, санхүүгийн салбар		
Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг	1,912,198,000 ширхэг энгийн хувьцаа		
Хагас жилийн тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр	Бэлтгэсэн:	Т. Буянбилэг /Хөрөнгө оруулагчдын харилцааны мэргэжилтэн, ТУЗ-ийн Ажлын алба/	
	Хянасан:	О. Ариунтулга /ТУЗ-ийн нарийн бичгийн дарга/	
1.	Хагас жилийн санхүүгийн тайлан		
1.1	Санхүүгийн байдлын үзүүлэлт		
САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН (СТОУС-д нийцсэн)			
<i>Төгрөг, мөнгөөр</i>			
	Балансын зүйл	Эцсийн үлдэгдэл 2023.12.31 Аудитлагдсан	Эцсийн үлдэгдэл 2024.06.30 Аудитлагдаагүй
1	ХӨРӨНГӨ		
1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	4,893,765,124,731.80	6,255,784,140,058.64
1.2	Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө	1,108,415,858,389.79	1,295,116,101,740.40
1.3	Хөрөнгө оруулалт	1,668,119,450,256.37	1,355,073,790,789.89
1.3.1	Арилжааны үнэт цаас	-	-
1.3.2	Борлуулахад бэлэн үнэт цаас	566,917,146,468.88	355,035,112,350.82
1.3.3	Хугацааны эцэс хүртэл эзэмших үнэт цаас	997,631,604,481.65	861,985,160,280.40
1.3.4	Зээл ба авлага гэж ангилсан бусад үнэт цаас	6,992,034,776.94	-

1.3.5	Хараат, хамтын хяналттай, охин компанид оруулсан хөрөнгө оруулалт	-	-
1.3.6	Барьцаанд байгаа үнэт цаас	68,104,991,830.46	116,534,713,018.19
1.3.7	Үнэт цаасанд хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	41,414,529,936.67	32,847,887,649.71
1.3.8	Үнэт цаасны эрсдэлийн сан	(12,940,857,238.23)	(11,329,082,509.23)
1.4	Зээл (цэвэр дүнгээр)	9,016,974,854,640.46	10,628,265,722,403.89
1.4.1	Хэвийн зээл	8,938,214,949,869.21	10,558,586,829,629.10
1.4.2	Хугацаа хэтэрсэн зээл	186,288,214,554.17	223,411,109,319.85
1.4.3	Хэвийн бус зээл	123,998,884,160.04	90,577,990,938.47
1.4.4	Эргэлзээтэй зээл	82,652,114,083.62	69,041,841,848.02
1.4.5	Муу зээл	303,334,333,077.43	344,686,205,192.48
1.4.6	Зээлийн хойшлогдсон төлбөр	(83,126,295,985.89)	(93,738,011,816.60)
1.4.7	Зээлд хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	118,062,549,835.40	145,126,335,453.46
1.4.8	Зээлийн эрсдэлийн сан	(652,449,894,953.52)	(709,426,578,160.89)
1.5	Дериватив санхүүгийн хөрөнгө	46,521,649,848.03	12,853,464,991.28
1.6	Бусад санхүүгийн хөрөнгө	6,820,398,576.79	12,708,787,269.41
1.7	Бусад санхүүгийн бус хөрөнгө	101,622,031,869.62	120,956,952,924.87
1.8	Үндсэн хөрөнгө	464,484,270,540.76	465,948,510,013.18
1.9	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	-	-
1.10	Борлуулах зориулалттай хөрөнгө	389,139,573.48	215,529,891.10
1.11	Биет бус хөрөнгө	43,529,293,922.69	39,015,223,282.98
1.12	Нийт хөрөнгийн дүн	17,350,642,072,349.80	20,185,938,223,365.64
2	ӨР ТӨЛБӨР		
2.1	Харилцах	4,490,351,136,888.14	5,693,453,974,665.98
2.2	Хадгаламж	7,638,617,568,980.25	9,014,541,042,444.33
2.3	Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр	2,417,172,739,165.79	2,522,714,797,833.51
2.4	Бусад эх үүсвэр	444,611,686,238.96	543,324,790,065.21
2.5	Дериватив санхүүгийн өр төлбөр	721,212,990.00	-
2.6	Бусад санхүүгийн өр төлбөр	185,222,890,984.49	221,125,746,090.55
2.7	Бусад санхүүгийн бус өр төлбөр	82,209,478,725.80	72,447,813,828.31
2.8	Хоёрдогч өглөг	-	-
2.9	Давуу эрхийн хувьцаа (өр төлбөр)	-	-
	Нийт өр төлбөрийн дүн	15,258,906,713,973.40	18,067,608,164,927.89
3	ӨӨРИЙН ХӨРӨНГӨ		
3.1	Хувь нийлүүлсэн хөрөнгө	191,219,800,000.00	191,219,800,000.00
3.2	Нэмж төлөгдсөн капитал	164,257,808,200.00	164,257,808,200.00
3.3	Халаасны хувьцаа	-	-
3.4	Дахин үнэлгээний нэмэгдэл	86,182,451,827.22	85,256,019,299.54
3.5	Хуримтлагдсан ашиг, алдагдал	1,649,038,590,069.83	1,669,389,812,605.67
3.6	Бусад өөрийн хөрөнгө	1,036,708,279.28	8,206,618,332.54
3.7	Өөрийн хөрөнгийн дүн	2,091,735,358,376.33	2,118,330,058,437.75
4	Өр төлбөр ба өөрийн хөрөнгийн дүн	17,350,642,072,349.80	20,185,938,223,365.64
1.2	Орлогын тайлан		

	Орлого, зардлын зүйл	Өмнөх үеийн дүн 2023.12.31	Тайлант үеийн дүн 2024.06.30
1	Хүүгийн орлого	2,052,185,427,491.23	1,209,997,947,020.55
2	Хүүгийн зардал	998,485,157,774.27	622,151,888,371.93
3	Хүүгийн цэвэр орлого [(1)-(2)]	1,053,700,269,716.96	587,846,058,648.62
4	Эрсдэлийн сангийн зардал	85,928,621,468.68	66,282,788,738.51
5	Эрсдэлийн сангийн дараах цэвэр орлого [(3)-(4)]	967,771,648,248.28	521,563,269,910.11
6	Бусад орлого	472,189,685,708.19	216,722,738,358.81
7	Бусад зардал	697,203,015,848.74	358,989,545,065.75
8	Татварын өмнөх ашиг, алдагдал (5+6-7)	742,758,318,107.73	379,296,463,203.17
9	Орлогын татварын зардал	183,975,449,096.69	88,855,850,655.01
10	Татварын дараах ашиг, алдагдал (8-9)	558,782,869,011.04	290,440,612,548.16
11	Зогсоосон үйл ажиллагааны цэвэр орлого, зардал	-	
12	Тайлант үеийн цэвэр ашиг, алдагдал (10+11)	558,782,869,011.04	290,440,612,548.16
13	Бусад дэлгэрэнгүй орлого	12,707,700,092.74	6,243,477,525.58
14	Тайлант хугацааны нийт дэлгэрэнгүй орлогын дүн (10+11)	571,490,569,103.78	296,684,090,073.74

1.3 Өмчийн өөрчлөлтийн тайлан

	Өөрийн хөрөнгийн зүйл	Хувь нийлүүлсэн хөрөнгө	Нэмж төлөгдсөн капитал	Халаасны хувьцаа	Дахин үнэлгээний нэмэгдэл	Бусад өөрийн хөрөнгө	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2022 оны 12-р сарын 31-ний өдрийн үлдэгдэл	172,097,820,000.00	-	-	88,384,096,825.57	(13,872,636,804.80)	1,268,756,787,060.44	1,515,366,067,081.21
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга							-
3	Залруулсан үлдэгдэл	172,097,820,000.00	-	-	88,384,096,825.57	(13,872,636,804.81)	1,268,756,787,060.44	1,515,366,067,081.20
4	Тайлант үеийн цэвэр ашиг, алдагдал	-	-	-	-	-	558,782,869,011.04	558,782,869,011.04
5	Бусад дэлгэрэнгүй орлого					14,909,346,091.09		14,909,346,091.09
6	Өмчид гарсан өөрчлөлт	19,121,980,000.00	164,257,808,200.00					183,379,788,200.00
7	Хуваарилсан ногдол ашиг	-		-	-	-	(180,702,711,000.00)	(180,702,711,000.00)
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	(2,201,644,998.35)		2,201,644,998.35	-
9	2023 оны 12-р сарын 31-ний өдрийн үлдэгдэл	191,219,800,000.00	164,257,808,200.00	-	86,182,451,827.22	1,036,708,279.28	1,649,038,590,069.83	2,091,735,358,376.33
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга							-
11	Залруулсан үлдэгдэл	191,219,800,000.00	164,257,808,200.00	-	86,182,451,827.22	1,036,708,279.28	1,649,038,590,069.83	2,091,735,358,376.33
12	Тайлант үеийн цэвэр ашиг, алдагдал	-	-	-	-	-	290,440,612,548.16	290,440,612,548.16
13	Бусад дэлгэрэнгүй орлого					7,169,910,053.26		7,169,910,053.26
14	Өмчид гарсан өөрчлөлт							-
15	Хуваарилсан ногдол ашиг	-		-	-	-	(271,015,822,540.00)	(271,015,822,540.00)
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	(926,432,527.68)		926,432,527.68	-
17	2024 оны 06-р сарын 30-ны өдрийн үлдэгдэл	191,219,800,000.00	164,257,808,200.00	-	85,256,019,299.54	8,206,618,332.54	1,669,389,812,605.67	2,118,330,058,437.75

1.4	Мөнгөн гүйлгээний тайлан		
<i>Төгрөг, мөнгөөр</i>			
	Үзүүлэлт	Өмнөх үеийн дүн	Тайлант үеийн дүн
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ:	***	***
1.1	Орлогын татварын өмнөх ашиг (алдагдал)	742,758,318,107.73	379,296,463,203.17
1.2	Орлого, зардлын тохируулга:	(800,165,567,911.19)	(473,782,384,918.30)
1.3	Хөрөнгө, өр төлбөрийн өөрчлөлтийн тохируулга:	(39,648,177,498.17)	730,427,783,874.94
1.4	Бусад тохируулга:	960,611,236,296.92	603,393,515,045.65
1.5	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	863,555,808,995.29	1,239,335,377,205.46
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ:	***	***
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	(1,385,405,326.81)	328,408,046,950.26
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	(69,275,098,605.00)	(33,448,175,225.28)
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(70,660,503,931.81)	294,959,871,724.98
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ:	***	***
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	183,379,788,200.00	98,739,588,936.40
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	(274,843,253,797.72)	(271,015,822,540.00)
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(91,463,465,597.72)	(172,276,233,603.60)
4	Валютын ханшийн зөрүү		-
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	701,431,839,465.76	1,362,019,015,326.84
6	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	4,192,333,285,266.04	4,893,765,124,731.80
7	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	4,893,765,124,731.80	6,255,784,140,058.64
2.	Хагас жилийн санхүүгийн тайланг хэлэлцэж, баталгаажуулсан төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аудитын хорооны дүгнэлт		
ТУЗ-ийн дэргэдэх Аудитын Хороо нь 2024 оны 7 дугаар сарын 04-ний өдрийн хурлаар ХААН Банк (“Банк” гэх)-ны эхний хагас жилийн санхүүгийн тайланг хэлэлцэн баталгаажуулсан болно.			
3.	Тайлант хугацаанд үнэт цаас гаргагчийн санхүүгийн үйл ажиллагаанд нөлөөлсөн гадаад, дотоод хүчин зүйлс, санхүүгийн тайлангийн шинжилгээ, орлого, зарлага, ашгийн үзүүлэлтүүдийг тооцож дүгнэсэн удирдлагын тайлан, дүгнэлт		
3.1	Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/		
<p>Нийт актив: 2024 оны эхний хагас жилийн байдлаар нийт актив 20.2 их наяд төгрөгт хүрч, 2023 оны эцэстэй харьцуулахад 16.3 хувийн өсөлт үзүүлсэн бөгөөд энэ нь нийт банкны систем дэх тэргүүлэх үзүүлэлт бөгөөд 2024 оны 1-р улирлаар 30.5 хувийг эзэлж байна.</p> <p>Нийт зээл: 2024 оны эхний хагас жилийн байдлаар нийт зээлийн багц 11.3 их наяд төгрөгт хүрч, 2023 оны эцэстэй харьцуулахад 1.7 их наяд төгрөг буюу 17.3 хувиар өссөн.</p> <p>Нийт татан төвлөрүүлсэн хөрөнгө:</p>			

Банкны нийт татан төвлөрүүлсэн хөрөнгө 18.6 хувь буюу 2.8 их наяд төгрөгөөр өсөж, 17.8 их наяд төгрөгт хүрлээ. Нийт татан төвлөрүүлсэн хөрөнгийн 83 хувийг харилцагчаас татсан эх үүсвэр, 17 хувийг банк, санхүүгийн байгууллагаас татсан зээллэг болон бусад эх үүсвэр бүрдүүлж байна.

Өөрийн хөрөнгө:

Нийт өөрийн хөрөнгийн хэмжээ өмнөх оны эцсээс 1.3 хувь буюу 26.6 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, 2.1 их наяд төгрөгт хүрсэн байна.

Ашигт ажиллагаа:

2024 оны эхний хагас жилд Банк 290.4 тэрбум төгрөгийн татварын дараах цэвэр ашигтай ажиллалаа. Үүнээс хүүгийн цэвэр орлого 587.8 тэрбум төгрөг буюу өмнөх оны мөн үеэс 105.9 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн нь голлох нөлөө үзүүллээ. Активын өгөөж 3.4 хувь, өөрийн хөрөнгийн өгөөж 28.5 хувьтай байна.

3.2 Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт

2024 оны 6 сарын 30-ны байдлаар Монголбанкны зохистой харьцаа үзүүлэлтүүдийг бүрэн хангаж ажилласан.

Өөрийн хөрөнгийн хүрэлцээ(>12%)

Нийт өөрийн хөрөнгийн хүрэлцээ өмнөх оны эцсээс 2.9 пунктээр буурч 15.73 хувьд хүрлээ.

I зэрэглэлийн өөрийн хөрөнгийн хүрэлцээ (>12%)

I зэрэглэлийн өөрийн хөрөнгийн хүрэлцээ өмнөх оны эцсээс 2.9 пунктээр буурч 15.73 хувьд хүрлээ.

Хөрвөх чадварын харьцаа(>25%)

Банкны хөрвөх чадварын харьцаа 45.2 хувь буюу зохистой харьцаа 25 хувиас дээш байх шалгуурыг бүрэн хангаж ажиллалаа.

Зээлийн чанар

Чанаргүй зээлийн багц 504.3 тэрбум төгрөг буюу нийт зээлд эзлэх хувь 4.5 хувь болж, өмнөх оны эцсээс 0.8 пунктээр буурлаа.

	2023	2024.06
Ашигт ажиллагаа		
Өөрийн хөрөнгийн өгөөж	31.7%	28.5%
Активын өгөөж	3.5%	3.4%
Зардал орлогын харьцаа	40.2%	41.9%
Зээлийн чанар		
Чанаргүй зээлийн харьцаа	5.3%	4.5%
Зээлийн эрсдэлийн сангийн хүрэлцээний харьцаа	127.9%	140.7%
Монголбанкны шалгуур		
Өөрийн хөрөнгийн зохистой харьцаа (>12%)	18.6%	15.7%
I-р зэрэглэл өөрийн хөрөнгийн харьцаа (>10%)	18.6%	15.7%
Хөрвөх чадварын харьцаа (>25%)	46.5%	45.2%
Нэгж гадаад валютын нээлттэй позицын харьцаа (+-15%)	-6.3%	-4.9%
Нийт гадаад валютын нээлттэй позицын харьцаа (+-30%)	-6.5%	-5.2%

3.3

Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчны нөлөөлөл, бүтээгдэхүүн, үйлчилгээний төрөл хэлбэрт гарч буй өөрчлөлт, дээрх өөрчлөлтөд компанийн зүгээс авч хэрэгжүүлж буй арга хэмжээний мэдээлэл

1. Макро Эдийн Засгийн Тойм


Макро эдийн засгийн орчны нөлөөллийн хувьд 2024 оны I улиралд уул уурхайн салбарын сэргэлт үргэлжилж, түүнийг дагасан тээврийн салбарын сэргэлтийн нөлөөгөөр бодит эдийн засаг 7.8%-иар өсөж, нэрлэсэн ДНБ 16.5 их наяд төгрөгт хүрэв. 2024 онд нүүрсний экспортын тоо хэмжээ өндөр түвшинд хадгалагдаж, Оюутолгойн зэс, алтны гарц нэмэгдэхээс гадна төсвийн зардлын тэлэлт, өрхийн хэрэглээний өсөлтөөс шалтгаалан бодит эдийн засгийн өсөлт 6.2 хувьд хүрэх төлөвтэй. 2024 оны 5-р сард улсын хэмжээнд инфляцын

эрч үргэлжлэн саарч 5.7%-д хүрэхэд валютын ханш тогтворжиж, импортын гаралтай инфляц буурсан нь голлон нөлөөлөв. Инфляцын төлөв байдал Монголбанкны зорилтын түвшинд тогтворжсонтой холбоотойгоор 2024 онд Монголбанкны зүгээс бодлогын хүүгээ 2 нэгж хувиар бууруулж 11%-д хүргэсэн бөгөөд цаашид мөнгөний бодлогын төлөв үргэлжлэн зөөлрөх хүлээлттэй байна.


2. Зах зээл эзлэлт

Банкны харилцагчийн депозит нь 2024 оны 5-р сарын байдлаар өмнөх оны эцсээс 3.7 хувиар өсөн 35.6%, нийт зээл нь 2 хувиар бууран 33.5%, нийт хөрөнгө нь 2 хувиар өсөн 32.4%, нийт эздийн өмч нь 1.4 хувиар бууран 32.3%-д хүрсэн тус тус үзүүлэлттэй байна.


Харилцагчийн депозит




Зээл



Нийт хөрөнгө



Өөрийн хөрөнгө



3. Бизнес төлөвлөгөөний гол чиглэл

Банкны дунд хугацааны тогтвортой стратеги нь Тогтвортой Хөгжлийн бодлоготой нягт уялдаж, Тогтвортой хөгжлийн 17 зорилтыг цогцоор нь стратегийн хувьд дэмжиж буй бөгөөд НҮБ-ын Глобал гэрээний зарчмуудыг тууштай баримталж, үйл ажиллагааны бүх чиглэлд илүү тогтвортой, хүртээмжтэй ирээдүйд үнэ цэн оруулахуйц зорилт бүхий стратеги юм.

Бид доорх үндсэн чиглэлүүдэд тэргүүлэх зорилтуудаа тодорхойлоод байна. Үүнд

3.1 Харилцагчийн туршлага:

Уг чиглэлд хялбар, шуурхай, найдвартай цахим сувгийн туршлагыг бүх сегментийн харилцагчдад хүргэж, үр дүнтэй түншлэл болон манлайллаар дамжуулан оролцогч талуудын харилцаа холбоог хангах, харилцагчийн асуудлыг шийдвэрлэх хамгийн сайн процессыг олон улсын хэрэглэгчийн туршлагын стандартын дагуу хэрэгжүүлэх. Түүнчлэн хиймэл оюунд суурилсан чатбот ашиглан санхүүгийн боловсрол, зөвлөгөө олгож хамгийн сайн харилцагчийн үйлчилгээг бий болгох, бүх сегментэд чиглэсэн санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх бүтээгдэхүүн үйлчилгээг сайжруулж, өгөгдлийн ашиглалт, машин сургалтад суурилж харилцагчдад тохирсон бүтээгдэхүүнийг санал болгох стратегийг тэргүүн чиглэл юм.

3.2 Бизнесийн өсөлтийг хангах:

Уг стратегийн хувьд хэрэглээний болон бизнесийн зээлийн багцын тэнцвэртэй өсгөж ногоон зээлийн багцыг 2025 онд нийт зээлийн 10 хувьд хүргэх болон хөрөнгө оруулалт, санхүүгийн төлөвлөлт, даатгалын бүтээгдэхүүнээр дамжуулан хувийн банкны бүтээгдэхүүн, үйлчилгээг сайжруулах юм.

Эрсдэлийн удирдлагын хувьд байгууллагын эрсдэлийн нэгдсэн удирдлагыг оновчтой болгох, эрсдэлийг үр дүнтэй удирдах замаар зээлийн чанарын өсөлтийг сайжруулах (чанаргүй зээл 5%-иас доош), олон улсын стандарт (ICAAP, ILAAP) хэрэгжилт, үнэлгээ, кибер аюулгүй байдал, байгаль орчин, нийгмийн удирдлагын тогтолцоог боловсронгуй болгох, уур амьсгалын эрсдэлийн менежментийг бий болгох замаар ногоон хөрөнгө оруулалтыг өргөжүүлэх, үйл ажиллагаа явуулахаар зорьж байна.

3.3 Цахим банкны стратеги:

Худалдан авалтын төлбөр тооцооны туршлагыг хялбарчилж, цахим хэтэвч ба цахим төлбөр тооцооны бизнес загварыг шинэчлэх, харилцагчийн амьдралын хэв маяг болон бизнесийн үйл ажиллагаанд зориулсан төлбөр тооцооны экосистемийг бүрдүүлж иргэн ба бизнесийн харилцагчдад санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх шилдэг технологийн үйлчилгээгээр хангах зорилттой. Түүнчлэн орчин үеийн технологи дээр суурилж бизнес

процесс автоматжуулах технологи, кодгүй, бага код бүхий хөгжүүлэлтийн платформ зэргийн тусламжтайгаар банкны хэмжээнд үйл ажиллагааг автоматжуулж үр ашгийг нэмэгдүүлэх стратеги зорилтыг тавьсан байна.

Байгууллагын хөгжил чиглэлд:

Банкны тогтвортой хөгжлийн бодлогыг ТХЗ ба ҮТХН-тэй нийцүүлэн өргөжүүлж, БОНЗ-ын тэргүүлэх чиглэл ба үзүүлэлтүүдэд хэмжигдэхүйц зорилтыг тогтооно. Хүний нөөцийн хувьд ажилтны туршлага, ажлын эерэг орчин, сэтгэл ханамж, хөдөлмөр эрхлэлтийн тэгш байдалд анхаарч тэргүүний ажил олгогч байр сууриа хадгалах, ажилтны цахим сэтгэлгээ, өгөгдлийн ашиглалтыг тасралтгүй хөгжүүлж, ажилтны бүтээмжийг сайжруулж бизнесийн амжилтад хүрэх тогтвортой хүний нөөцийн туршлагыг хэрэгжүүлэхээр тус тус зориод байна.

4. Бүтцийн өөрчлөлт

Банк нь ирэх гурван жилийн стратегид нийцэх, зах зээлийн нөхцөл байдлын өөрчлөлт, үйл ажиллагааны үр ашигтай байдлыг нэмэгдүүлэх зорилгоор бүтэц зохион байгуулалтыг шинэчилсэн. 2024 оны 4-р сарын 22-ны өдрийн ТУЗ-ийн 13 тоот тогтоолоор дараах газар нэгжүүдийг нэмэн байгуулсан болно. Үүнд:

1. Стратеги төлөвлөлт, хяналт удирдлагын газар
2. Зээлийн бүтээгдэхүүн хөгжүүлэлт, Ногоон банкны газар
3. Өгөгдлийн удирдлагын газар
4. Бизнесийн үйл ажиллагаа сайжруулалтын газар
5. Зээлийн өгөгдөл шинжилгээний газар
6. Зээлийн эрсдэлийн дэмжих алба
7. Байгууллагын эрсдэлийн удирдлагын газар
8. Бренддинг, олон нийттэй харилцах газар
9. Өгөгдөл засаглал, чанарын удирдлагын газар
10. Хүний нөөцийн бизнес түншлэлийн газар

Зохион байгуулалтын бүтцийн дэлгэрэнгүйг Банкны цахим хуудаснаас харна уу. / <https://www.khanbank.com/personal/about/about-structure/>

3.4

Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлого

Болзошгүй өр төлбөр ба үүрэг

Банк нь харилцагчдынхаа санхүүгийн хэрэгцээнд зориулж төрөл бүрийн буцаах нөхцөлгүй болзошгүй өр төлбөр болон үүргийг хүлээдэг. Хэдийгээр эдгээр үүргүүдийг санхүүгийн байдлын тайланд тусгадаггүй ч эдгээр нь тодорхой хэмжээний эрсдэлийг агуулж байдаг тул Банкны нийт эрсдэлийн нэг хэсэг гэж үздэг.

	2024 оны 6 сарын 30			2023 оны 12 сарын 31		
<i>Мянган төгрөгөөр</i>	Нийт дансны үнэ	Зээлжих эрсдэлийн сангийн зардал	Дансны үнэ	Нийт дансны үнэ	Зээлжих эрсдэлийн сангийн зардал	Дансны үнэ
Болзошгүй өр төлбөр						
Банкны олгосон баталгаа	169,246,132	(943,485)	168,302,647	142,011,464	(751,531)	141,259,933
Аккредитив	43,198,768	(374,214)	42,824,554	27,347,449	(185,163)	27,162,286
Ашиглагдаагүй зээлийн шугам	1,126,094,859	(12,370,020)	1,113,724,839	636,504,815	(10,317,573)	626,187,242
Ашиглагдаагүй кредит карт	36,324,027	(241,949)	36,082,078	52,416,065	(1,279,543)	51,136,522
Факторингийн авлага	1,734,369	(7,405)	1,726,964	200,000	(1,054)	198,946
Нийт болзошгүй өр төлбөр	1,376,598,155	(13,937,073)	1,362,661,082	858,479,793	(12,534,864)	845,944,929
Капиталын үүргүүд						
Үндсэн хөрөнгө	1,362,866		1,362,866	1,025,293		1,025,293
Нийт	1,377,961,021	(13,937,073)	1,364,023,948	859,505,086	(12,534,864)	846,970,222

Балансын гадуурх үүргийн хүлээгдэж буй эрсдлийн алдагдлын сангийн зардал:

<i>Мянган төгрөгөөр</i>	Ашиглагдаагүй зээлийн шугам	Ашиглагдаагүй кредит карт	Банкны олгосон баталгаа	Аккредитив	Факторингийн авлага	Нийт дүн
2024 оны 1 сарын 01-р дансны үнэ	636,504,815	52,416,065	142,011,464	27,347,449	200,000	858,479,793
Тайлант жилд олгосон болон худалдан авсан/өсөлт	2,452,574,025	47,542,792	324,416,143	42,438,398	2,699,676	2,869,671,034
Үл хүлээн зөвшөөрсөн эсвэл төлөгдсөн	(1,962,983,981)	(63,634,830)	(297,181,476)	(26,587,081)	(1,165,307)	(2,351,552,675)
2024 оны 6 сарын 30-наар (аудитлагдаагүй)	1,126,094,859	36,324,027	169,246,132	43,198,768	1,734,369	1,376,598,155
2024 оны 1 сарын 01-р хүлээгдэж буй эрсдлийн алдагдлын сан	10,317,573	1,279,543	751,531	185,163	1,054	12,534,864
Шинээр олгосон болон худалдан авсан	23,774,410	686,302	1,629,541	421,532	16,849	26,528,634
Үл хүлээн зөвшөөрсөн эсвэл төлөгдсөн	(20,780,366)	(1,819,007)	(1,437,587)	(232,481)	(10,498)	(24,279,939)
ХБЭА шилжилтийн нөлөө	(941,597)	95,111	-	-	-	(846,486)
Тайлант хугацааны цэвэр зардал	2,052,447	(1,037,594)	191,954	189,051	6,351	1,402,209
2024 оны 6 сарын 30-наар (аудитлагдаагүй)	12,370,020	241,949	943,485	374,214	7,405	13,937,073

Үүрэг

Үүрэг гэдэг нь Банкны зүгээс зээл олгох, зээлийн шугам нээх гэрээт үүргүүдийг хүлээснийг илэрхийлдэг. Ийм үүргүүд нь тогтсон дуусах хугацаа эсвэл цуцлах бусад төрлийн заалтуудтай байдаг. Зээл олгох үүрэг нь хэрэгжээгүй байтал тус үүргийнх нь хугацаа дууссан байж болох тул гэрээнд заасан дүн нь ирээдүйн мөнгөний шаардлагыг илэрхийлдэг гэсэн ойлголт биш юм.

4.

Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй хэлцэл болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийгдэх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл

Банк нь сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцлийг холбогдох хууль тогтоомж болон 2024 оны 2 дугаар сарын 15-ны өдрийн ТУЗ-ийн хурлаар шинэчлэн баталсан “Ашиг сонирхлын зөрчилтэй хэлцэл болон Их хэмжээний хэлцэл хийх бодлого”-д нийцүүлэн байгуулдаг болно.

Банкны холбогдох этгээд (Нэгдмэл сонирхолтой этгээд)	Активын хэлбэр	Үлдэгдэл дүн	Өөрийн хөрөнгийн эзлэх хувь	
1	Банкны холбогдох нэг этгээд (нэгдмэл сонирхолтой этгээд)-д олгосон зээл болон зээлтэй адилтган тооцох бусад актив (Өөрийн хөрөнгийн 5 хувиас хэтрэхгүй)			
1.1	Банкны хувьцаа эзэмшигч	Зээл/баталгаа	10,693.1	0.50%
1.2	Банкны эрх бүхий албан тушаалтан	Зээл	5,022.5	0.24%
1.3	Банкны бусад холбогдох этгээд	Зээл/баталгаа	76,537.8	3.61%
2.	Банкны нийт холбогдол этгээдүүд (нэгдмэл сонирхолтой этгээдүүд)-д олгосон зээл болон зээлтэй адилтган тооцох бусад актив (Өөрийн хөрөнгийн 20 хувиас хэтрэхгүй)			
2.1	Банкны нийт хувьцаа эзэмшигчид	Зээл/баталгаа	201,727.7	9.52%
2.2	Банкны эрх бүхий албан тушаалтнууд	Зээл	10,598.2	0.50%
2.3	Банкны бусад холбогдох этгээд	Зээл/баталгаа	76,537.8	3.61%

Банк нь тайлант хугацаанд их хэмжээний хэлцэл хийгээгүй болно.

5.

Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор олон нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойших төслийн хэрэгжилтийн явц, татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан, мэдээлэл

Банк нь 2023 оны 4 дүгээр сарын 13-ний өдрөөс 2023 оны 4 дүгээр сарын 19-ний өдрийн хооронд олон нийтэд 959 төгрөгийн нэгж үнэ бүхий 191,219,800 ширхэг энгийн хувьцааг санал болгох замаар нийт 183,379,788,200 (нэг зуун наян гурван тэрбум гурван зуун далан есөн сая долоон зуун наян найман мянга хоёр зуу) төгрөгийг татан төвлөрүүлсэн.

Тус Банк нь энгийн хувьцааг нийтэд санал болгон арилжсанаар өөрийн хөрөнгөө нэмэгдүүлснээс гадна татан төвлөрүүлэх хөрөнгийн 16 хувийг банкны бүтээгдэхүүн үйлчилгээний цахим шилжилтийг хурдасгах мэдээллийн технологийн хөрөнгө оруулалтад, 19 хувийг цахим бүтээгдэхүүний хөгжүүлэлт, шинэчлэлтэд, 34 хувийг ногоон төсөл хөтөлбөрүүдэд болон 31 хувийг урт хугацаатай хөрөнгө оруулалтын зээл, орон сууцны зээл санхүүжүүлэхэд зарцуулахаар төлөвлөсөн.

Мөн дунд хугацаанд харилцагчийн сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх, зайнаас хүргэх үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх, өрсөлдөх чадвараа сайжруулахад чиглэсэн цахим шилжилтийн зорилтуудаа хэрэгжүүлэх, зах зээлд эзлэх байр сууриа хадгалах, тэлэх зорилтуудыг дэвшүүлсэн.

Нийт татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалт 2024 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар дараах байдалтай байна. Үүнд:

№	Зарцуулалт	Эзлэх хувь	ТТХ дүн /төгрөг/	Зарцуулалт	Эх үүсвэрийн үлдэгдэл
1	Мэдээллийн технологийн хөрөнгө оруулалт	16%	29.3 тэрбум	29.3 тэрбум	0
2	Цахим бүтээгдэхүүний хөгжүүлэлт, сайжруулалт	19%	34.8 тэрбум	29.2 тэрбум	5.6 тэрбум
3	Ногоон төсөл, хөтөлбөрүүдийн санхүүжилт	34%	62.4 тэрбум	62.4 тэрбум	0
4	Урт хугацаат зээл /Орон сууц, хөрөнгө оруулалтын санхүүжилт/	31%	56.9 тэрбум	56.9 тэрбум	0
	Нийт	100%	183.4 тэрбум	177.8 тэрбум	5.6 тэрбум

Нийт татан төвлөрүүлсэн хөрөнгийн эх үүсвэрийн үлдэгдэл нийт 5.6 тэрбум төгрөг байна.

6. Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

Банкны Төлөөлөн Удирдах Зөвлөл (“ТУЗ” гэх) нь тус Банкны хувьцаа эзэмшигчдийн төлөөлөл болон хараат бус гишүүдээс бүрдсэн нийт 9 гишүүний бүрэлдэхүүнтэй. ТУЗ нь Компанийн тухай хууль, Банкны тухай хууль, Монголбанкнаас баталсан журам, заавар, Банкны Дүрэм, Компанийн засаглалын кодекс, ТУЗ-ийн үйл ажиллагааны журам болон бусад холбогдох эрх зүйн бичиг баримтыг мөрдөн банкны зохистой засаглалыг хэрэгжүүлэн үйл ажиллагаа явуулдаг.

ТУЗ-ийн чиг үүрэг

- Банкны стратегийг тодорхойлох, хянан үзэж түүнд нэмэлт өөрчлөлт оруулах, зохион байгуулалтын бүтэц, эрсдэлийн удирдлагын бодлого, жилийн төсөв, бизнес төлөвлөгөө, үйл ажиллагааны үр дүнгийн үзүүлэлтийг батлах;
- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах;
- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал хуралдуулахгүйгээр хувьцаа эзэмшигчдээс эчнээ санал хураалт явуулах замаар асуудлыг шийдвэрлүүлэх;
- Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудал, саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг гаргах бүртгэлийн өдөр болон хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулахтай холбогдох бусад асуудлыг шийдвэрлүүлэх;
- Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хувьцаа эзэмшигчдийн баталсан хувьцааны төрөл болон тоонд багтаан хувьцаа гаргах;
- Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хувьцаа эзэмшигчдийн баталсан төрөл болон тоонд багтаан Банкны дүрэмд заасан хувьцаанд хамаарахаас бусад үнэт цаас гаргах;
- Компанийн тухай хуулийн 55 дугаар зүйлд заасны дагуу эд хөрөнгийн болон эд хөрөнгийн эрхийн зах зээлийн үнийг тогтоох;
- Өөрийн гаргасан хувьцаа, бусад үнэт цаасыг худалдан авах буюу эргүүлэн авах тухай шийдвэр гаргах;
- Монголбанкны Ерөнхийлөгчтэй зөвшилцөн банкны гүйцэтгэх удирдлагыг томилох, түүний бүрэн эрхийг тогтоох;
- Гүйцэтгэх удирдлагын бүрэн эрх, хариуцлагыг тогтоох, үйл ажиллагаанд нь хяналт тавих, түүний цалин, урамшууллын хэмжээг тогтоох;
- Банкны дотоод аудитын нэгжийг гүйцэтгэх удирдлагаас хараат бусаар зохион байгуулж, түүний төсөв, орон тоог батлах, гүйцэтгэх удирдлага, ажилтныг томилох, үйл ажиллагааны журмыг тогтоох, цалин, урамшууллын хэмжээг тогтоох;
- Хөндлөнгийн аудитын байгууллагыг сонгож, түүнтэй байгуулах гэрээний нөхцөлийг тогтоох;
- Банкны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар дүгнэлт гаргаж, түүнийг хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулж батлуулах;

- Банкны дүрэмд өөрөөр заагаагүй бол ногдол ашгийн хэмжээ, түүнийг төлөх журмыг тодорхойлох;
- Төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны болон банкны зохистой засаглалын бодлого, журмыг тогтоож хэрэгжилтэд хяналт тавих;
- Банкны салбар болон төлөөлөгчийн газар байгуулах;
- Банк өөрчлөн байгуулах талаар хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийн төслийг бэлтгэх, гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх;
- Их хэмжээний хэлцэл хийх зөвшөөрөл олгох;
- Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгох;
- Компанийн тухай хууль, Банкны тухай хууль болон компанийн дүрмээр тогтоосон бусад асуудал багтана.

Банкны ТУЗ-ийн гишүүн бүр Компанийн тухай хууль, Банкны тухай хуульд заасан үүргээс гадна дараах үүрэг хүлээнэ. Үүнд:

- Хууль, тогтоомж болон дүрмээр олгогдсон бүрэн эрхийн хүрээнд ажил, үүргээ хариуцлагатай биелүүлэх;
- Банкны эрх ашгийг хувийн болон өөрийг нь томилсон хувьцаа эзэмшигчдийн эрх ашгаас дээгүүр тавих;
- Нууцаар ашиг хүртэхгүй байх;
- Сонирхлын зөрчлөөс зайлсхийж, сонирхлын зөрчил үүссэн үед ТУЗ-д мэдээлдэг байх;
- Банкны өдөр тутмын үйл ажиллагаанд оролцохгүй байх;
- Банкны Гүйцэтгэх захиралд хяналт тавих, ажлын үр дүнгийн тайланг улиралд нэгээс доошгүй удаа авч хэлэлцэх, хувьцаа эзэмшигчдэд эрх тэгш хандах;
- Хувьцаа эзэмшигч, харилцагч болон хадгаламж эзэмшигчийн эрх ашгийг хамгаалах;
- Банкны бодлого, стратеги, эрсдэл даах сонирхлыг тодорхойлох, банканд үр ашигтай шийдвэр гаргах;
- Банкны нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлангийн тогтолцоо, хөндлөнгийн болон дотоод аудит, эрсдэлийн удирдлага, санхүүгийн болон үйл ажиллагааны хяналт, хууль тогтоомжийн хэрэгжилт, банкны бүтцийн өөрчлөлт зэрэг Гүйцэтгэх захирлын үйл ажиллагаанд хяналт тавих;
- ТУЗ-өөс Гүйцэтгэх захиралтай байгуулах гэрээнд эрх, үүрэг, хариуцлага, үйл ажиллагаанд хяналт тавих, тайлагнах тогтолцоог бүрэн тусгаж, гэрээний биелэлтийг улирал бүр дүгнэх;
- Банкны удирдлагыг сонгон шалгаруулах, тэдгээрийн залгамж халааг бэлтгэх төлөвлөгөөг батлах, төлөвлөгөөнд удирдах дээд албан тушаал бүрд тавигдах ажил мэргэжлийн шаардлага, чиг үүргээ үр дүнтэй гүйцэтгэхэд хангалттай түвшинд бэлтгэхийг тодорхой тусгасан байх;
- Гүйцэтгэх захирлын урамшууллын асуудлыг банкны эрхэм зорилго, урт хугацааны хэтийн зорилго, стратеги төлөвлөгөө, ёс зүйн хэм хэмжээ болон гэрээнд заасан үүргийн биелэлт зэрэгтэй уялдуулан шийдвэрлэх;
- Хууль тогтоомж болон Банкны дүрмээр олгогдсон бүрэн эрхийн хүрээнд ажил үүргээ хариуцлагатай, үнэнч шударгаар гүйцэтгэж, чандлан сахих;
- Ашиг сонирхлын зөрчлийн улмаас банкны өмнө хүлээсэн үүргээ зүй ёсоор хэрэгжүүлэхэд саад тотгор үзүүлэх үйлдэл, эс үйлдэл гаргахгүй байх;
- Монгол Улсын хууль тогтоомж болон олон улсын стандартад заасан шаардлагыг хангасан байгууллагыг сонгон шалгаруулж, хөндлөнгийн аудит хийлгэх;
- Банкны дотоод аудитын нэгжээс хийсэн шалгалтын акт материал, ажлын тайлан зэргийг цаг тухайд нь авч хэлэлцэн, зохистой засаглал болон дотоод хяналтын тогтолцоог сайжруулах талаар Гүйцэтгэх захиралд үүрэг өгөх, авсан арга хэмжээний үр дүнг тооцох;
- Өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэхдээ мэдлэг ур чадвараа дайчлан, хичээл зүтгэл гарган ажиллах.

Банкны ТУЗ-ийн хараат бус гишүүн нь Компанийн тухай хууль, Банкны тухай хуульд заасан үүргээс гадна дараах үүрэг хүлээнэ. Үүнд:

- ТУЗ, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаа, гаргасан шийдвэр нь тухайн банкны эрх ашигт сөргөөр нөлөөлөх эсэхэд хяналт тавих, хувьцаа эзэмшигчдэд мэдэгдэх;
- ТУЗ, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаа нь хууль тогтоомжид нийцсэн эсэхэд хяналт тавих;
- Банкны харилцагч, хадгаламж эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах;

- Компанийн тухай хуульд заасан сонирхлын зөрчилтэй хэлцэл, холбогдох этгээдийн хэлцэл, их хэмжээний хэлцлийг хэлэлцэхэд заавал оролцож санал өгөх;
- ТУЗ болон гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаа, бодлого, шийдвэр нь банкны үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлсөн, хууль тогтоомжийг зөрчсөн тохиолдолд ТУЗ-ийн хараат бус гишүүн уг зөрчлийг арилгахыг холбогдох этгээдээс шаардах, шаардлагыг эс биелүүлэх тохиолдолд уг асуудлыг ТУЗ-д тавьж шийдвэрлүүлэх, улмаар хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулах шаардлагыг ТУЗ-д хүргүүлэх;
- Хувьцаа эзэмшигч, ТУЗ болон гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаа, бодлого, шийдвэр нь банкны эрх ашигт сөргөөр нөлөөлөх, хууль тогтоомжийг зөрчих тохиолдол бүрд Монголбанканд мэдэгдэх, улмаар хүсэлт гарган банканд шалгалт хийлгэх;
- ТУЗ-ийн хараат бус гишүүн тус бүр нь өөрийн үндсэн үүргийн хэрэгжилт, ажлын тайлан зэргийг Монголбанканд болон хувьцаа эзэмшигчдийн хуралд жилд нэгээс доошгүй удаа тайлагнах;
- Аудитын болон Эрсдэлийн хорооны бүрэлдэхүүнд заавал орж ажиллах.

ТУЗ нь Банкны үйл ажиллагаанд дараах байдлаар оролцохыг хориглоно:

- ТУЗ-ийн гишүүн болон түүний төлөөлж буй аж ахуйн нэгж, байгууллага нь банканд зээл, баталгаа, батлан даалтын гэрээгээр хүлээсэн аливаа үүрэг, төлбөр нь чанаргүй ангилалд орсон тохиолдолд тус гишүүнийг ТУЗ-ийн хуралд саналын эрхтэй оролцуулах;
- Банкны өдөр тутмын үйл ажиллагаанд оролцох.

Гүйцэтгэх захирал нь ТУЗ-ийн гишүүнээр томилогдон ажиллах тохиолдолд ТУЗ-ийн үйл ажиллагаанд дараах байдлаар оролцохыг хориглоно:

- Аудитын хороо болон Эрсдэлийн хорооны бүрэлдэхүүнд саналын эрхтэйгээр орж ажиллах;
- Гүйцэтгэх захирлын бүрэн эрх, хариуцлагыг тогтоох, үйл ажиллагаанд нь хяналт тавих, түүний цалин урамшууллын хэмжээг тогтоох;
- Гүйцэтгэх захирлын үйл ажиллагаанд үнэлгээ, дүгнэлт өгөх.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН БҮТЭЦ:

Банкны 2023 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн ТУЗ-ийн 28 тоот тогтоолоор ТУЗ-ийн даргаар хатагтай Т.Дарьбум, ТУЗ-ийн дэд даргаар хатагтай Д.Хулан нарыг тус тус сонгосон.

ТУЗ-ийн хараат бус гишүүд:

- Т. Дарьбум – ТУЗ-ийн дарга, хараат бус гишүүн
- Ханс Аарт Йонгеянс – ТУЗ-ийн хараат бус гишүүн
- А. Тамир – ТУЗ-ийн хараат бус гишүүн

ТУЗ-ийн ердийн гишүүд:

- Д. Хулан – ТУЗ-ийн дэд дарга, ердийн гишүүн
- Иший Кисабүро – ТУЗ-ийн ердийн гишүүн
- Ц. Баатарсайхан – ТУЗ-ийн ердийн гишүүн
- Харада Ясүнари – ТУЗ-ийн ердийн гишүүн
- Б. Амарсанаа – ТУЗ-ийн ердийн гишүүн
- Жон Ло – ТУЗ-ийн ердийн гишүүн

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДЭРГЭДЭХ ХОРООД:

ТУЗ-ийн дэргэдэх Хороод тус бүрийн чиг үүрэг, үйл ажиллагаа, бүтэц бүрэлдэхүүн, гишүүдийн эрх үүрэг, тэдгээрт тавигдах шаардлага зэрэг бусад асуудлыг хороодын дүрэм, Банкны Дүрэм, ТУЗ-ийн үйл ажиллагааны журмаар нарийвчлан зохицуулагддаг. Холбогдох журам, зааврын зохистой байдлыг хадгалах үүднээс хороод Дүрмээ хянаж, шаардлагатай тохиолдолд нэмэлт өөрчлөлт оруулах, шинэчлэн найруулах саналыг ТУЗ-д хүргүүлдэг.

Банкны 2024 оны 3 дугаар сарын 13-ны өдрийн ТУЗ-ийн 07 тоот тогтоолоор ТУЗ-ийн дэргэдэх хороодын бүрэлдэхүүнийг шинэчлэн баталсан. Үүнд:

№	ТУЗ-ийн дэргэдэх хороод	Хорооны дарга	Хорооны гишүүд
---	-------------------------	---------------	----------------

1	Аудитын хороо	А. Тамир (хараат бус гишүүн)	Ханс Аарт Йонгегянс (хараат бус гишүүн) Иший Кисабүро
2	Эрсдэлийн хороо	Т. Дарьбум (хараат бус гишүүн)	Ц. Баатарсайхан Ханс Аарт Йонгегянс (хараат бус гишүүн)
3	Засаглал, Цалин урамшууллын хороо	А. Тамир (хараат бус гишүүн)	Харада Ясүнари Т. Дарьбум (хараат бус гишүүн)
4	Нэр дэвшүүлэх, Хүний нөөцийн хороо	Ханс Аарт Йонгегянс (хараат бус гишүүн)	А. Тамир (хараат бус гишүүн) Д.Хулан

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ

Банкны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2024 оны 4 дүгээр сарын 23-ны өдөр танхим болон цахимаар буюу хосолсон хэлбэрээр Хүүхдийн 100 тооцооны төвийн 1 давхарт байрлах ХААН театрт амжилттай зохион байгуулагдсан бөгөөд энэхүү хуралд нийт саналын эрхтэй хувьцаа эзэмшигчид 87.76 хувийн ирцтэй оролцож, дараах шийдвэрүүдийг хэлэлцэн баталсан. Үүнд:

1. “ХААН Банк” ХК-ийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлт;
2. ТУЗ-ийн 2024 оны зардлын төсөв;
3. “ХААН Банк” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журмын төслийг тус тус хэлэлцэж батлав.

ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГА

Банкны Дүрмийн 13.1-д заасны дагуу гүйцэтгэх удирдлагыг ТУЗ-өөс томилогдсон гүйцэтгэх захирал дангаараа хэрэгжүүлнэ. Гүйцэтгэх захирал нь Банкны өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, хяналт тавьж, хувьцаа эзэмшигчдийн болон ТУЗ-ийн гаргасан бүх шийдвэр, тогтоолын зохих хэрэгжилтийг хангана. Түүнчлэн ажил үүргээ ТУЗ-тэй байгуулсан гэрээ болон холбогдох итгэмжлэлд заасан эрх хэмжээний дотор Банкны өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах (Компанийн тухай хууль 83.1) бөгөөд Банкны гүйцэтгэх удирдлагыг Монголбанкны зөвшөөрснөөр (Банкны тухай хууль 31.3.2) ТУЗ томилж түүний үйл ажиллагаанд хяналт тавина.

ТУЗ-ийн 2020 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 18 тоот тогтоолоор хатагтай Р.Мөнхтуяа Гүйцэтгэх захирлаар томилогдон ажиллаж байна. Гүйцэтгэх захирлын өдөр тутмын болон шуурхай үйл ажиллагаанд туслах үүрэгтэй Гүйцэтгэх удирдлагын баг ажиллана.

Монгол Улсын Компанийн тухай хууль болон Банкны тухай хуульд ТУЗ нь гүйцэтгэх удирдлагатай байгуулах гэрээний нөхцөл, гүйцэтгэх удирдлагын бүрэн эрх, хариуцлагыг тогтоох, үйл ажиллагаанд хяналт тавих, түүний цалин урамшууллын хэмжээг тогтоохоор заасныг үндэслэн Гүйцэтгэх захирал жил бүр ТУЗ-д өөрийн ажлын тайланг танилцуулж, дараа жилийн цалин, урамшууллын хэмжээг ТУЗ-ийн дэргэдэх Засаглал, Цалин урамшууллын хорооны саналыг үндэслэн тогтоодог.

Банкны ТУЗ-ийн 2024 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн 13 тоот тогтоолоор Банкны зохион байгуулалтын бүтцийг шинэчилсний дагуу Гүйцэтгэх удирдлагын баг дараах бүрэлдэхүүнтэй ажиллаж байна. Үүнд:

- Р.Мөнхтуяа – Гүйцэтгэх захирал;
- Б.Эрдэнэдэлгэр – Бизнес хариуцсан Гүйцэтгэх захирлын тэргүүн орлогч;
- Сачин Наир – Технологи, үйл ажиллагаа хариуцсан Гүйцэтгэх захирлын орлогч;
- Г.Мөнхбаяр – Эрсдэл хариуцсан Гүйцэтгэх захирлын орлогч;
- Д.Энхбаатар – Иргэдийн банк хариуцсан дэд захирал;
- Ж.Товуудорж – Жижиг дунд бизнесийн банк хариуцсан дэд захирал;
- Ч.Чинболд – Бизнес хөгжил хариуцсан дэд захирал;
- Т.Ууганбаяр – Байгууллагын банк хариуцсан дэд захирал;
- Б.Ариунболд – Мэдээллийн технологи хариуцсан дэд захирал;
- Д.Ариунбат – Үйл ажиллагаа хариуцсан дэд захирал;
- Д.Өлзийжаргал – Санхүүгийн эрсдэл хариуцсан дэд захирал;
- Ю.Төрмөнх – Стратеги хариуцсан дэд захирал;
- Ш.Өлзий-Аюуш – Санхүү хариуцсан дэд захирал;

- Ш.Ганбямба – Хүний нөөц хариуцсан дэд захирал;
- Д.Дугарбаатар – Ерөнхий аудитор;
- О.Ариунтулга – ТУЗ-ийн нарийн бичгийн дарга.

7. Үнэт цаас гаргагчийн засаглалтай холбоотой тайлан, мэдээлэл

ХУВЬЦАА ЭЗЭМШЛИЙН БҮТЭЦ

Банкны нийт гаргасан 1,912,198,000 ширхэг энгийн хувьцааг 2024 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар нийт 30,757 хувьцаа эзэмшигч эзэмшиж байна. Үүнд:

№	Хувьцаа эзэмшигчийн нэр	ХААН Банкны хувь нийлүүлсэн хөрөнгөнд эзлэх хувь	Хувьцааны тоо ширхэг
1	Эйч Эс Холдингс ХК	40.99%	783,882,300
2	Эйч Эс Интернэйшнл (Ази) Лимитед ХХК	8.78%	167,856,050
3	Таван Богд Холдингс ХХК	22.78%	435,653,100
4	Д.Хулан (хувь хүн)	13.22%	252,738,000
5	Олон нийт	14.23%	272,068,550
Нийт:		100.00%	1,912,198,000

Хувьцаа эзэмшигчдийн талаар:

Эйч Эс Холдингс ХК	Токиогийн хөрөнгийн биржид бүртгэлтэй “Эйч Эс Холдингс” ХК (ТҮО: 8699) нь санхүүгийн бизнес эрхэлдэг компаниудын хувьцааг эзэмшдэг холдинг компани бөгөөд харилцан хамаарал бүхий компаниудтай. Эдгээр нь Эйч Эс Интернэйшнл (Ази) Лимитед, Эйч Эс Секюритис ХХК, Эйч Эс Сэрвисэр ХХК, Солид Банк ХК, ХААН Банк ХК болон Кыргызкоммерцбанк ХК зэрэг болно.
Эйч Эс Интернэйшнл (Ази) Лимитед ХХК	Эйч Эс Интернэйшнл (Ази) Лимитед компани нь Эйч Эс Холдингс ХК-ийн 100 хувийн эзэмшилтэй Хонгконг дахь охин компани юм. Тус компани нь Хятад болон Ази тивийн эдийн засгийн өсөлт дээр тулгуурлан “Эйч Эс Холдингс” ХК-ийн Ази дахь стратегийг хэрэгжүүлж, бүс нутгийн улс орнуудын зах зээлийн судалгаа хийхээс гадна Хонконгийн зах зээл дээр бизнесийн үйл ажиллагаа эрхэлдэг.
Таван Богд Холдингс ХХК	Таван Богд Холдингс ХХК нь Таван Богд Группийн толгой компани ба 1997 онд Группийн бодлого стратеги, менежментийг нэгдсэн байдлаар тодорхойлох, шинэ бизнесийг нээн хөгжүүлэх, хөрөнгө оруулалт болон салбар компаниуддаа менежментийн дэмжлэг үзүүлэх зорилготойгоор байгуулагдсан. Таван Богд Групп нь худалдаа үйлчилгээ, үйлдвэрлэл, аялал жуулчлал болон зочид буудал, уул уурхайн тоног төхөөрөмжийн бэлтгэн нийлүүлэлт, банк санхүү зэрэг салбарт үйл ажиллагаа явуулдаг.
Д.Хулан (хувь хүн)	Монгол Улсын иргэн Д.Хулан нь Таван Богд группийн үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигч бөгөөд одоогоор тус группийн ТУЗ-ийн даргаар ажиллаж байна. Тэрээр Банкны ТУЗ-ийн ердийн гишүүн, ТУЗ-ийн дэд дарга бөгөөд 2010 оноос бие даасан хувьцаа эзэмшигч болсон.
Олон нийт	Банк нь Банкны тухай хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд 2021 оны 2 дугаар сараас эхлэн нээлттэй хувьцаат компани болох бэлтгэл ажлыг холбогдох хууль, журамд заасан хугацаанд, шат дараатайгаар хийж ирсэн бөгөөд зохицуулагч байгууллагуудаас холбогдох зөвшөөрлүүдийг хүлээн авсны дагуу анхдагч зах зээлийн арилжааны нээлтийг 2023 оны 04 дүгээр сарын 13-ны өдөр хийсэн. Банк нийт хувьцааныхаа 10 хувь буюу 191,219,800 ширхэг хувьцааг олон нийтэд санал болгосон нь Монголын хөрөнгийн зах зээлийн хамгийн өндөр дүнтэй, хамгийн олон захиалга

авсан, хамгийн олон хөрөнгө оруулагчидтай, хамгийн хүртээмжтэй анхдагч зах зээлийн арилжаа болсон бөгөөд тус хувьцаа одоо Монголын хөрөнгийн биржид нээлттэй арилжаалагдаж байна.

Банкны хувьцаа эзэмшигчдийн 2021 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн 9 тоот тогтоолоор баталсан “ХААН Банкны ажилтанд хувьцаа худалдах хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх зөвшөөрлийг Монголбанкнаас 2022 оны 01 дүгээр сарын 28-ны өдөр хүлээн авснаар тус Банкны 4,136 ажилтанд 80,848,750 ширхэг хувьцааг эзэмшүүлсэн. Тус хөтөлбөрийн оролцогчидтой хийсэн гэрээний дагуу 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөс эхлэн хувьцааг нээлттэй арилжаалагдах болсон.

НОГДОЛ АШГИЙН МЭДЭЭЛЭЛ

Банк нь Ногдол ашгийн бодлогыг Банкны ТУЗ-ийн 2023 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн 26 тоот тогтоолоор шинэчлэн баталсан. Ногдол ашгийн бодлогын зорилго нь Банкны ТУЗ-өөс баримтлах ногдол ашгийн бодлого, ногдол ашиг хуваарилах нөхцөл, журмыг Банкны тухай хууль, Компанийн тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомж болон зохицуулагч байгууллагуудаас гаргасан холбогдох дүрэм, журамд нийцүүлэн тодорхойлоход оршино. Тус Бодлогод заасны дагуу Банк нь татварын дараах цэвэр ашгийн 40 хувиас дээш хувиар ногдол ашиг хуваарилахыг эрмэлзэж ажилладаг. Зохицуулалттай үйл ажиллагаа эрхэлдэг компанийн хувьд Монголбанкнаас зөвшөөрөл олгосноор хувьцаа эзэмшигчдэд ногдол ашгаа тараах эрхтэй болдог.

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 46.1, 46.5, Банкны Дүрмийн 9.13.14, Банкны Ногдол ашгийн бодлого болон ТУЗ-ийн 2024 оны 2 дугаар сарын 15-ны өдрийн 04 тоот тогтоол, мөн Монголбанкнаас ирүүлсэн 2024 оны 4 дүгээр сарын 19-ний өдрийн А/16/277 тоот зөвшөөрлийн дагуу тус Банкны 2023 оны татварын дараах цэвэр ашиг болох нийт 558 тэрбум төгрөгийн банкны өөрийн эрсдэл даах чадвар, өөрийн хөрөнгийн зохистой харьцааг зохих хэмжээнд барих нөхцөлийг хангасны үндсэн дээр 48.5 хувь буюу 271 тэрбум төгрөгийг нэгж хувьцаанд 141.73 төгрөгөөр тооцож 2024 оны 4 дүгээр сарын 05-ны өдөр буюу хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүртгэлийн өдрийн байдлаар Банкны хувьцааг эзэмшиж байсан нийт 29,865 хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг болгон мөнгөн хэлбэрээр хуваарилсан.

ИЛ ТОД БАЙДАЛ

Банк нь хувьцаат компанийн хувьд сайн засаглалын туршлагуудаас суралцах, хэрэгжүүлэх, мэдээллийн нээлттэй ил тод байдлын зарчмыг баримтлан хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигч, олон нийтийг шаардлагатай мэдээллээр ханган ажиллаж байгаа бөгөөд өөрийн болон Биржийн цахим хуудсаар тухай бүр мэдээ, мэдээллийг нийтэлж байгаа болно. ТУЗ-ийн 2015 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн 27 тоот тогтоолоор батлагдсан Мэдээллийн ил тод байдал, мэдээллийг толилуулах бодлогын дагуу ил тод байдлыг баримталж ажилладаг.

2024 оны 1-р хагас жилд нийт 20 тайлан, мэдээллийг холбогдох хууль болон журмын хугацаанд Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн биржид хүргүүлж, олон нийтэд тайлагнасан.

ДОТООД АУДИТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Банкны Дотоод аудит нь Ерөнхий аудиторын харьяанд үйл ажиллагаа явуулдаг бөгөөд Монгол Улсын Банкны тухай хуулийн дагуу ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороонд харьяалагдаж, Гүйцэтгэх удирдлагаас хараат бусаар зохион байгуулагдсан байдаг.

Дотоод аудит нь Дотоод аудиторуудын институт (The IIA)-аас боловсруулсан Олон улсын мэргэжлийн практикийн хүрээний заавал дагаж мөрдөх элементүүд буюу Дотоод аудитын мэргэжлийн практикийн олон улсын стандартууд, Ёс зүйн дүрэм, Дотоод аудитын мэргэжлийн практикийн үндсэн зарчмууд, Дотоод аудитын тодорхойлолт зэрэгт үйл ажиллагаагаа нийцүүлэн ажилладаг.

Дотоод аудитын үндсэн чиг үүрэг:

- Салбарын аудитын газар нь Иргэдийн банкны салбар, тооцооны төвүүдийн засаглал, эрсдэлийн удирдлага, хяналтын тогтолцоо болон тэдгээрт дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий Төв банкны газар, албад, зээлийн хороодын үйл ажиллагаанд аудитыг хийж гүйцэтгэнэ.

- Төв банкны аудитын газар нь Төв банкны харьяа газар, хэлтэс, алба, хороодын үйл ажиллагаа болон төсөл, хөтөлбөрүүдийн засаглал, эрсдэлийн удирдлага болон хяналтын тогтолцоонд аудитыг хийж гүйцэтгэнэ.
- Мэдээлэл технологийн аудитын газар нь банкны мэдээллийн технологи, мэдээллийн системийн үйл ажиллагаа, тэдгээрийн эрсдэлийн удирдлага, мэдээллийн аюулгүй байдлыг хамарсан аудитыг хийж гүйцэтгэнэ. Мөн Дотоод аудитын үйл ажиллагааг сайжруулахад чиглэсэн систем хөгжүүлэлт, судалгаа шинжилгээ, мэдээлэл боловсруулалтыг хариуцна.

Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр: Р. Мөнхтуяа

Албан тушаал: ХААН Банк ХК- Гүйцэтгэх захирал

Гарын үсэг:

Огноо: 2024 он 7 сар, 19 өдөр

